

**СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2021 оны 07 дугаар сарын мэдээлэл

2021.07.23.

“Овоот”

Төрийн удирдлагын чиглэлээр:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгдийн Тэргүүлэгчдийн хурлыг 2 удаа зохион байгуулж, уг хурлаар дараахь асуудлыг хэлэлцэв. Үүнд:

-Сумын төвд V баг байгуулах ажлын хэсэг байгуулах.

- V хуралдааны тов тогтоож Төсвийн тодотгол хэлэлцэх.

2. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн болон Засгийн газрын 05 дугаар тогтоолоор батлагдсан журам, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан журмын хүрээнд төрийн албан хаагчдын 2021 оны хагас жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэж, хамт олны үнэлгээг нууцаар авч, нэгтгэн дүгнэлээ.

3/.Сумын Засаг даргын 2021.07.09 ний өдрийн А/88 дугаар захирамжаар цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан “ Суманд ирэх буцах иргэд, тээврийн хэрэгслийг 2021.07.10 ны 08 цагаас эхлэн хяналтын цэгээр дамжуулан, шаардлагатай тохиолдолд түргэвчилсэн шинжилгээ авч, олон хоногоор саатах иргэдийг гэрийн ажиглалт, тусгаарлалтад авч хяналт хийхээр зохион байгуулан ажиллаж байна.

4/. Сумын Засаг даргын 2021.07.19 ний А/89 дүгээр захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй “**Хэлний бодлогын зөвлөл**”-ийг байгуулан ажиллаж байгаа.

5/. 2022 оны төсвийн төсөөлөлд санал авч, нэгтгэн хүргүүлэхээр бэлтгэж байгаа бөгөөд 2021 оны хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн Сангийн Яамны программд шивж орууллаа.

Сургалт сурталчилгааны чиглэлээр.

-Монгол Улсын Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх асуудлаарх Зүүн бүсийн цахим хэлэлцүүлэгт иргэд, төрийн албан хаагчдыг оролцуулж саналаа Барилга хот байгуулалтын Яамны Bolormaa9691@ gmail.com хаягаар хүргүүллээ.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: -Сумын Засаг даргын 2021.07.08 ны өдрийн А/87 дугаар захирамжаар “Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх хуваарийг баталж, 2021.07.09-2021.08.01 ний дотор багтаан тарилгыг хийж дуусгахаар зохион байгуулалтын арга хэмжээг аваад байна.

Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын чиглэлээр.

- “Дарьганга тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ- нь “Одкон холдинг” ХХК-тай хамтран инженерийн нэгдсэн системийн иж бүрэн шинэчлэл хийгдэх төслийн ажлын сургалтанд 11 залууг хамруулан, 7,5 тэр бум төгрөгийн санхүүжилтээр уг ажлыг зохион байгуулахаар гэрээг байгуулан ажиллаж байна.

-6,6 тэрбум төгрөгийн төсөв санхүүжилтээр Хүүхдийн зуслангийн барилгын шинэчлэл бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Сүхбаатар Аймгийн ИТХ-ын төлөөлөгч , ЗДТГазрын дарга П. Мөнхжаргал ,аймгийн ИТХ-ыг төлөөлөгч БОАЖ-ын газрын дарга О.Батнасан нар коронавируст халдварын үеийн бэлэн байдал, шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэлд зориулан 1000000 төгрөг , 1000 ширхэг амны хаалт , 100 ширхэг хамар залгиурын түргэвчилсэн шинжилгээгээр туслалцаа үзүүллээ.

Нөхцөл байдлын мэдээ: 2021-07-23 нд 24 цагийн байдлаар:

Батлагдсан тохиолдол:☆ Шинээр- 0 ☆ Нийт батлагдсан тохиолдол - 18
Үүнээс: Том хүн – 16, эрэгтэй - 7, эмэгтэй – 9, Хүүхэд -эрэгтэй 2,эмэгтэй – 0,Эмчлүүлж байгаа: Сүхбаатар аймагт – 0, Суманд - 1 биеийн байдал хүндэвтэр , Улаан бүсэд 1 их эмч 1 туслах сувилагч ороод ажиллаж байна. Сүхбаатар аймаг руу явуулсан ойрын хавьталын пср-н 28 шинжилгээний хариу бүгд сөрөг гарсан. Эдгэрсэн: 17 /гэрийн ажиглалтанд шилжсэн.

Соёлын чиглэлээр:

-TITGNS PICTURES KINO компанийн төслийн багтай хамтарч өв соёлын тухай баримтат Телевизийн бичлэг хийх ажлыг зохион байгууллаа

-Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан Дарьганга өв соёлоо патентжуулах бренд болгож эдийн засгийн эргэлтэнд оруулах тухай хэлэлцүүлэг болсон. Өв соёлыг суртчилан таниулж хамтарч ажиллах талаар аймгийн засаг даргын орлогч Мөнхзаяа Дарьганга өв соёлыг гүйцэтгэх Гантуяа захиралтай хамтарч Дарьганга дээл хувцасны судалгаа хийж хэрэгжүүлэх талаар хамтарч ажилахаар болов.

НЭГТГЭСЭН:

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР